

# “ХӨВСГӨЛ” ХК

2024 оны 04 сарын 30

№ 24/02

Улаанбаатар хот

## “ХӨВСГӨЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн зарласан энгийн хувьцааны тоог нэмэгдүүлэх

Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1.16 дахь заалт, 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 24/01 тоот Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн зарласан энгийн хувьцааны тоог нэг бүр нь 100 (нэг зуу) төгрөгийн нэрлэсэн үнээр тооцон 86,655,338 (наян зургаан сая зургаан зуун тавин таван мянга гурван зуун гучин найм) ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлж, нийт 86,707,294 (наян зургаан сая долоон зуун долоон мянга хоёр зуун ерэн дөрөв) ширхэг байхаар тогтоосугай.
2. Компанийн зарласан хувьцааны тоонд багтаан гаргах хувьцааны тоо, гаргах хэлбэр, гаргах хугацаа, нөхцлийг тогтоох эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, Компанийн зарласан энгийн хувьцааны тоонд орсон өөрчлөлтийг холбогдох байгууллагад бүртгүүлэх, шаардлагатай бусад арга хэмжээг авч ажиллах, холбогдох баримт бичигт Компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захиралд олгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.УЯНГА